

**“Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллэзтой тэмцэх төсөл”-ийн
хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны
үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан**

2008.04.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллэзтой тэмцэх ” төслийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулах.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан “*Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам*”-ыг арга зүйн үндэс болгов.

Төслийн нэгдсэн тайланг уншиж судалсны дараа Эрүүл мэндийн байгууллагууд, Үндэсний статистикийн газраас гаргасан мэдээ, мэдээллийг судлан харьцуулан дүгнэх аргаар дүн шинжилгээ хийв.

Мөн Сэлэнгэ, Архангай, Булган, Төв аймгийн зарим сумдад томилолтоор ажиллан төслийг хэрэгжүүлж буй анхдагч нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсаны зэрэгцээ Ховд, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай аймгийн нийт малын эмч нартай уулзаж санал солилцох, асууж магадлах, асуумжаар судалгаа авах арга хэлбэрүүдээр мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн болно.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үнэлгээ

“Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллэзтой тэмцэх төсөл”-ийг Засгийн газрын 2001 оны 206 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлжээ. Төслийн 2 дахь үе шат 2005 онд дууссан ба одоо 3 дахь шатандаа хэрэгжиж байна. Төсөл 2009 он хүртэл үргэлжилнэ.

Энэхүү төслийг батлан хэрэгжүүлэхдээ “Хүний эрүүл мэнд, улс нийгэм, эдийн засагт нотцой хохирол учруулдаг малын бруцеллэзоос мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, Монгол Улсын экспортын боломжийг нэмэгдүүлж, улс орны эдийн засаг, малчдын ахуй амьдралыг дээшлүүлэх” зорилгыг тавьсан байна.

Төслийн хүрээнд 2007 онд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

- Бруцеллэзоос сэргийлэх вакциныг Баян-Өлгий, Өмнөговьос бусад аймгуудын 384.9 мянган бод, 3450.3 мянган бог нийт 3835.3 мянган малд хийхээр тооцон Биокомбинат төрийн өмчит үйлдвэрийн газартай гэрээ байгуулан ажилласан ба вакциныг гэрээнд заагдсан 5, 6 дугаар сард орон нутгийн мал эмнэлгийн албанд нийлүүлсэн байна.
- Бруцеллэзын РЕВ-1 вакцины үнэ 292.37 сая төгрөг, 19 дүгээр омгийн вакцинд 54.46 сая төгрөг нийт 346.8 сая төгрөгний санхүүжилтийг вакцин үйлдвэрлэгч байгууллагад шилжүүлсэн байна.

- Вакцинжуулалтын үйлчилгээний хөлс 197.4 сая төгрөгийг ХХААЯ-ны Мал эмнэлгийн газраас орон нутагт олгожээ.
- Бруцеллёзын шинжилгээнд 354500 мал хамруулахаар тооцсон ба оны эцсийн гүйцэтгэлээр 400008 толгой мал хамрагдаж төлөвлөгөөг 112.8 хувь биелүүлэв. Улсын хэмжээнд 699 толгой малд бруцеллёз өвчин оношлогдсон ба дундаж халдварлалт 0.32 хувь байна. Шинжилгээгээр бруцеллёзын халдварлалт Төв аймагт 3.8 хувь, Дундговь аймагт 1.37 хувь, Орхон аймагт 0.64 хувь байгаа нь улсын дунджаас өндөр байна.
- Бруцеллёзтой тэмцэх арга хэмжээний үр дүнг тодорхойлох зорилгоор Архангай аймгийн 24103, Ховд аймгийн 23848 толгой малыг хамруулан тандалт шинжилгээ хийсэн. Энэ ажлыг ХХААЯ-ны МЭГ, МЭЭШХ, Архангай, Ховд аймгийн Мал эмнэлгийн албаны мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан нарын бүрэлдхүүнтэйгээр хамтран зохион байгуулж 2007 оны 06 сард багтаан хэрэгжүүлэв.
- “Бруцеллёзын тандалт шинжилгээнд хэрэглэх зүү, зүү баригч, вакуумт хуруу шил, ийлдэсний цодон нийлүүлэгчийг сонгох” нээлттэй тендерт Монветмед ХХК шалгарч вакуумт хуруу шил 49038 ширхэг, цус авах зүү 49038 ширхэг, зүү баригч 980 ширхэг, ийлдэс хадгалах цодон 24000 ширхэгийг гэрээнд заагдсан хугацаанд нийлүүлж шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.
- Бруцеллёз өвчнийг оношлох нэвчин тундасжих урвалын цомог нийлүүлэх гэрээг Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй 2007 оны 5 сарын 10-ны өдөр байгуулсан ба 8575.0 мянган төгрөгийн үнэ бүхий 24.5 мянган тун НТУ-ын цомгийг Архангай, Ховд аймгуудын ХХААГ-г гэрээнд заагдсан хугацаанд бүрэн хэмжээгээр нийлүүлсэн байна.

3.1. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа		2007 онд хийгдсэн ажлын хэмжээ		
		Төлөвлөлт /тоо/	Гүйцэтгэл	
			/тоо/	хувь
Бруцеллёзийн голомт, халдварын түвшин тогтоох тандалт шинжилгээ хийх	Хамрагдсан нийт мал	354500	400008	112.8%
Ээмэгжүүлэх	Хамрагдсан нийт мал /мян.тол/	х	0	0%
РЕВ-1 болон 19 дүгээр омгийн вакцинаар урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх	Нийт мал /мян.тол/	3835.2	3835.2	100%
	Охин тугал /мян.тол/	384.9	384.9	100%
	Охин хурга, ишиг /мян.тол/	3450.3	3450.3	100%
Бүх, хуц, ухны бруцеллёзийн шинжилгээ /мян.тол/		х	х	100%
Халдварын голомтод халдваргүйтгэл хийх		х	х	100%

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ээмэгжүүлэх ажил огт хэрэгжихгүй яваад байгаа. Хэрэгжээгүй байгаа шалтгааны талаар тодруулахад хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйтэй холбон тайлбарлаж байв. Малчид ээмэгжүүлэлтийн ач холбогдолыг ойлгохгүй байгаагийн улмаас малдаа ээмэг зүүлгэх дургүй байдаг тухай нэгэн малын эмч мэдээллэж байсан. Ээмэгжүүлэлт хийгдээгүй нь ихээхэн хөрөнгө, цаг хугацаа зарж хэрэгжүүлсэн тандалт шинжилгээний үр дүнг үнэ цэнэгүй болгох нөхцөл байдалд хүргэж болзошгүй тул энэ асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг өмнөх жилийн үнэлгээний тайланд дурьдсан байгаа. Тандалт шинжилгээгээр

ганц хоёр хонь бруцеллёзийн халдвар авсан нь тогтоогдлоо гэж бодъё. Та түүнийг олж нядлуулж чадах уу гэж асуухад энэ бол боломжгүй малчин аль малыг заана түүнийг л хэрэгцээлүүлэхээс өөр аргагүй гэсэн хариултыг уулзсан ихэнх мэргэжилтнүүд өгч байсан. Түүвэр маягаар цөөн мал сонгосон үед буцааж таних боломжтой, харин бүх малыг хамруулж шинжилгээ хийсэн үед энэ асуудал том бэрхшээл авчрах нь тодорхой байна.

Мөн төслийн баримт бичигт зааснаар хээлтүүлэгч малыг жилд 2 шинжилж байх ёстой. Бид Архангай аймагт очиж МЭ-ийн ажилтай танилцах үед хээлтүүлэгчийг жилд нэг л удаа шинжилж амжиж байгаа тухайгаа мэдээллэсэн тул энэ ажил яагаад хэрэгжихгүй байна вэ? гэдгийг асууж судаллаа. Шинжилгээг зөвхөн аймгийн төвийн лабораторид хийх боломжтой. Тэнд ажиллаж буй хүмүүс жилд 2 удаа бүх сумыг тойрч ажиллах цаг хугацааны боломж байдаггүй юм байна. Иймээс хүний нөөц хүрэлцдэггүйтэй холбоотойгоор хээлтүүлэгчийг жилд зөвхөн нэг удаа л шинжилгээнд хамруулдаг байна.

Бух бол нэг хотонд удаан тогтдоггүй мал. Тиймээс бруцеллёзийн шинжилгээний дээж авахаар очих үед бух олдохгүй байх тохиолдол их байдаг гэсэн бэрхшээл олон дурьдагддаг. Гэтэл аймгуудаас хээлтүүлэгчийг 100% шинжилгээнд хамруулсан гэсэн мэдээлэл ирүүлж байгаа. Орон нутгаас ирүүлж буй мэдээллийн үнэмшилийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй байгаа нь эндээс харагдаж байна.

Дээрхээс бусад ажлууд төлөвлөгөөний дагуу сайн хэрэгжсэн байна.

3.2. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ

2007 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөт арга хэмжээнүүдийн үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг доорх хүснэгтээр харууллаа.

Шалгуур үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Төсөл хэрэгжихийн өмнөх түвшин буюу 2000 он	Төслийн 2 дахь шат дуусах үе буюу 2005 онд хүрсэн түвшин	2007 онд хүрсэн түвшин
Хөдөөгийн хүн амын бруцеллёзийн	Халдварлалт	%	16,1	0,2	х
		Мян.хүн	6,6 /нийт/	0,042	х
	Өвчлөлт	%	9,5	х	х
		Мян.хүн	3,9 /нийт/	0.836	0.421
10000 хүн тутамд жилд шинээр илрэх тохиолдол	тоо	5.0	3.3	1.6	
Нийт малын тоо	Үхэр	Мян.тол	3097.6	1963.6	2425.8
	Хонь	Мян.тол	13876.4	12884.5	16990.1
	Ямаа	Мян.тол	10269.8	13267.4	18347.8
Малын бруцеллёзийн халдварлалт	Шинж. нийт мал/өвчтэй мал		х	344400/527	400008 /699
	%		1.0-8.0 (ДО, ХЭ, ТӨ, СЭ, ХӨ, БӨ)	0,15	0.18
Сувайралт	Үнээ	Тол		Асуумжаар авсан судалгаагаар малчдад мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан болох нь тогтоогдсон	
	Бог мал	Тол			
Хээл хаялт	Үнээ	Тол			
	Бог мал	Тол			

Хүний бруцеллёзийн өвчлөлийн тоо нь энэ төслийн үнэлгээний гол шалгууруудын нэг байдаг. 2007 оны байдлаар улсын хэмжээнд бруцеллёзын өвчлөл 86 тохиолдлоор буурсан ч Архангай, Дорнод, Дорноговь, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгуудад өвчлөл улсын дунджаас их байна гэсэн судалгааг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс /ХӨСҮТ/ гаргаж нийтэд мэдээллэжээ. Эрүүл мэндийн салбарын статистик мэдээллээс үзвэл шинээр бүртгэгдсэн өвчлөлийн тоо өмнөх оноос 123-аар буурсан байна. 10000 хүн амд ноогдох тоо 1.6 байгаа нь сүүлийн 5 жилийн дундажаас яг 2 дахин бага байна. Эдгээр үзүүлэлтүүд нь энэ хөтөлбөр зохих үр дүнгээ өгч байна гэж дүгнэх үндэслэл болж байгаа юм.

Улсын хэмжээнд бруцеллёз өвчний учир 9500 өвчтөн хяналтанд байгаа ба өвчлөгсдийн 55.3%-ийг малчид, 13.0%-ийг ажилчин, 6.9%-ийг албан хаагч, 6.9%-ийг эрхэлсэн ажилгүй иргэд, 10.7%-ийг өндөр настан, 7.2%-ийг 14 хүртэлх насны иргэд эзэлж байгаа юм байна. Өвчилсөн иргэдийн 89.2%-д ахуйн хавьтлаар, 6.5%-д хүнсний бүтээгдэхүүнээр, 4.3%-д мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр халдвар дамжсаныг судалгаар тогтоосон байна. Энэ нь иргэд өөрийгөө халдвараас хэрхэн хамгаалах талаар мэдлэг багатай байгааг илэрхийлж байгаа ба нөгөө талаар бруцеллёз өвчний хор хохиролыг төдийлөн сайн ухаарахгүй байгааг илэрхийлж байгаа юм. Орон нутагт ажиллан төслийн үр дүнтэй танилцаж байхад малчдыг мэдлэгжүүлэх, тэдний үзэл бодолд эргэлт гаргах, тэдэнд тогтсон буруу зуршилийг өөрчлөн засах талаар МЭҮН болон хүн эмнэлгийн салбар аль аль нь идэвх санаачлага туутай ажиллаж байгаа нь харагдаж байсан.

Малын хээл хаялт, сувайралт нь энэ төслийн үр дүнгийн нэгэн шалгуур мөн боловч үүнийг тоон баримтаар илэрхийлэх боломжгүй байна. Учир нь сатистикийн газраас гаргаж буй тоон мэдээлэлд халдвартай болон халдваргүй өвчнөөс шалтгаалсан сувайралт, хээл хаялтыг ялгаж мэдээллэдэггүй юм. Иймээс малчдаас асуулга авах аргаар тандах судалгаа хийсэн. Асуулганд хамрагдсан малчдын олонх нь малын хээл хаялт, сувайралт тэдэнд мэдэгдэхүйц хэмжээгээр багасаж байгаа гэсэн хариултыг өгсөн байна. Нийт мал сүргийн тоо толгой ихээхэн хэмжээгээр өсөж байгааг дан ганц бруцеллёз өвчний халдварлалт буурч байгаатай холбон тайлбарлах нь учир дутагдалтай ч малын тооны өсөлтөнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй.

Нийт аймгийг хамруулан хийж байгаа шинжилгээнд хамрагдах хээлтэгч малын тоо цөөн учраас төлөөлөх чадвар хангалттай байж чаддаггүй. Иймээс жилд 2-3 аймгийг сонгож гүүнээс бусад хээлтэгч малыг хангалттай хэмжээгээр хамруулан хийж буй шинжилгээний дүнг төслийн үр дүнгийн тогтворжилтийн гол үзүүлэлт болгон авч үзлээ. Энэ жилийн тандалтаар Ховд аймгийн үхэр сүрэг 0.4%, бог мал 0.01%-ийн халдварлалттай гарсан байна. Харин Архангай аймгийн үхэр сүргийн 1.25%, бог малын 0.04% өвчний халдвар авсан байжээ. Үүн дээр үндэслэн төслийн үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнгийн тогтворжилт аймаг бүрт харилцан адилгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Бруцеллёзийн шинжилгээ хийхдээ аймаг бүрээс цөөн тооны мал аймгийг хамруулан хавтгайруулж байгаа арга хэлбэрээс татгалзаж тодорхой бүс нутгийн бүх малын хамруулж шинжлэх хэлбэрээр зохион байгуулах нь илүү оновчтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл 2-3 аймгийг хамруулан хийж буй тандалт шинжилгээг 4-5 аймаг болгож өргөжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Дөрөв. Үнэлгээ

	Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ	Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ	Төслийг хамтран хэрэгжүүлэх байгууллага, мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагын үнэлгээ	Дундаж үнэлгээ
Хувь	82.4	85.0	75.0	80.8
Оноо	4.12	4.25	3.75	4.04

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс мал ээмэгжүүлэх ажил огт хийгдэхгүй байгаа тухай дээр өгүүлсэн. 2007 оны гүйцэтгэлийг 5 гол үйл ажиллагааны дунджаар гаргахад 82.4% байна.

Төсөл нэгэнт төгсгөлийн шатандаа орсон тул ажлын үр дүн, үр нөлөөг судлах зайлшгүй шаардлага гарч ирж байгаа. Төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийн ихэнх нь биелэсэн байгаагаас гадна тоон өөрчлөлтийн хувьд эерэг хандлагатай байгаа нь харагдаж байна. Гэхдээ малын бруцеллёзийн халдварлалтын хувь бүх аймагт жигд буурахгүй байгааг үндэслэн 85.0%-ийн үнэлгээ өгсөн. Бруцеллёзтой малыг хэрэгцээлүүлэх ажилд хяналт тавих механизмаа олж чадахгүй байгаа аймгуудад малын өвчлөл буурахгүй байна гэсэн дүгнэлт хийж байна.

Төсөлийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг жигд татан оролцуулах талаар толгойлох байгууллага анхаарах шаардлагатай байгаа юм. Ялангуяа Эрүүл мэндийн салбарынханы ажлыг хэрхэн уялдуулж өгөх вэ гэдгийг бодох хэрэгтэй байна. Бруцеллёзтой тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн болон ХХАА-н сайдын хамтарсан тушаал гарсан хэдий ч бодит ажил болж чадахгүй байна. Жишээлбэл, АР, ХО аймагт малын бруцеллёзийн тандалт хийж байхад эрүүл мэндийн яам мөн тэр нутагт тандалт хийгээд хүний халдварлалтын түвшинг тогтоочихвол ихээхэн ач холбогдолтой дүгнэлт гарах боломж бүрдэнэ. Эрүүл мэндийн салбарын одоогийн мэдээлэл эмнэлэгт өөрөө ирсэн хүнээр л хязгаарлагдаж байгаа тул цаана нь хичнээн хүн халдвар тээгээд явж байгааг хэлэх боломж алга. Энэ мэтчилэнгээр төсөлд үүрэг гүйцэтгэж буй байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаанд анхаарах асуудал их байгаа тул 75.0%-ийн үнэлгээ өгсөн болно.

Төслийн 2007 оны дундаж үнэлгээ 80,8% буюу 4,04 оноогоор “хангалттай” гэсэн үнэлгээтэй байна.

Тав. Дүгнэлт

- ◆ Архангай, Ховд аймагт хийсэн тандалт шинжилгээ нь малын бруцеллёзын халдварлалт, тархалтын түвшинг аймаг, сум, баг, суурийн түвшинд тодорхойлох боломж олгож байгаа тул төслийн үр дүнг үнэлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон байна.
- ◆ “Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллезтой тэмцэх төсөл”-ийг 2000 оноос хэрэгжүүлж эхлэхээс өмнө Архангай, Ховд аймгийн үхэр сүрэг дунджаар 2-2.5%, бог мал 0.4-0.6% -ийн халдвар лалттай байсан бол вакцинжуулалтын үр дүнд үхэр сүрэг 0.4-1.25 %, бог мал 0.01-0.04% болж буурсан байна. Архангай аймагт үхэр сүргийн бруцелллёзын халдварлалт өндөр хэвээр байгаа нь тогтоогдлоо.
- ◆ Эрүүл мэндийн салбарын статистик мэдээнээс үзэхэд шинээр өвчилсөн тохиолдол улсын хэмжээгээр 2005 онд 836, 2006 онд 544 бүртгэгдэж байсан бол 2007 онд 421 болж буурсан байна. Шинээр өвчлөх тохиолдол тасралтгүй буурч байгаа нь энэ төслийн гол үр дүн юм.
- ◆ Хээлтүүлэгчийг жилд 2 удаа шинжилгээнд хамруулах, халдварлалтын түвшин тогтоох тандалт шинжилгээг бүх малыг хамруулан хийх зэрэг томоохон ажлуудыг

гүйцэтгэхэд орон нутаг дахь хүний нөөц дутагдсаны улмаас зарим ажлууд хэрэгжиж чадахгүй байдалд хүрч байна.

- ◆ Ээмэгжүүлэх ажлыг хийхгүй байгаа нь шинжилгээгээр өвчин илэрсэн хээлтэгч бог малыг таньж хэрэгцээлэх ажилд бэрхшээл учруулж, өвчин шинээр тархах нөхцөл байдлыг үүсгэхээр байна.

Зургаа. Санал, зөвлөмж

- 2008 онд төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлтийн хүрсэн байх түвшинг нарийн зааж оруулан батлуулах хэрэгтэй.
- Малчдыг бруцеллёз өвчний талаар зохих мэдлэгтэй болгохын тулд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлыг илүү үр дүнд хүргэх шаардлагатай байна.
- Халдварлалтын түвшин тогтоох тандалт судалгаагаар өвчтэй гарсан малыг хэрэгцээлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нөхцөлийг хангахын тулд хээлтэгч бог малыг ээмэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Хүн хүч хүрэлцэхгүй байх бэрхшээл тулгардаг томоохон ажлуудыг гүйцэтгэхдээ ХААИС-ийн МЭБС-тэй хамтран ажиллаж малын эмчийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг оролцуулан зохион байгуулвал нэг талаас ажлын чанар, нөгөө талаас бэлтгэж буй мэргэжилтний чанар чансааг сайжруулахад тустай байх болно.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын мэргэжилтэн:

С.Дивангар

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын дарга:

Д.Бат-Эрдэнэ